



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1.Ашигт малтмал, газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа аймаг, сумын орон нутгийн хөгжлийн санд тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж буй ашигт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчийн улсын төсөвт төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг хуваарилах чиглэлээр хууль тогтоомжийн төсөл боловсруулж, Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Р.СЭДДОРЖ